**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ**

Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код**: ГАА-2025/010/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтайхот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор:Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер:Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:tserenkhandd@audit.gov.mn<br>Аудитор: С.Санчирмаа<br>Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 17 № 114

танай ____________ -ны № ____________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Т.ЭРХЭМБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 13 дугаар зүйлийн 13.7, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 8 дугаар зүйлийн 8.2, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дах зүйлтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тэнүүн Алтайн Шарга хязгаарлагдмал хариуцлагатай компаниас 335,475.0 мянган төгрөгийн нүүрсийг худалдан авахдаа баталгаажсан хэмжих хэрэгслээр пүүлсэн баримтгүй, бүрдэл хангаагүй анхан шатны баримтаар орлого авсан,
- Нийт 52,550.5 мянган төгрөгийн зуухны сэлбэг хэрэгсэл, засварын ажлыг хийлгэхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй,
- Тайлант онд 79,056.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, 14,914.4 мянган төгрөгийн өглөг, 66,124.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс 20,685.0 мянган төгрөгийн нүүрс

8225020323

худалдан авсан зэрэг өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлэлгүй, зөрчлийг давтан гаргасан,

- Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн дагуу урамшууллын санг байгуулаагүй боловч, албан хаагчдын ажлыг дүгнэсэн материалгүйгээр 30,544.7 мянган төгрөгийг олгосон,
- Цахим дэлгүүрээс 1,450.0 мянган төгрөгийн компьютер худалдан авалт хийгээгүй,
- Үйлчилгээний хөлс 1,720.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын халаалтын тариф нэмэгдсэнтэй холбоотой орлого нэмэгдэж, 49,970.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үүссэн авлага, өглөгийг хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Үйл ажиллагаа буюу дулаан авах иргэдийн тоо өссөнөөс зуухны галч 4 орон тоогоор нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус байгууллагын төсөв захирагч 5 зорилт, 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Засаг даргаас биелэлтийг 96.0 хувиар дүгнэсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны үзүүлэлт | Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 408,047,405.73 | 528,948,030.09 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,179,784.75 | 37,220,802.39 |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 2,179,784.75 | 37,220,802.39 |
| 31210 | Төгрөг | 2,179,784.75 | 37,220,802.39 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 2,179,784.75 | 37,220,802.39 |
| 33 | АВЛАГА | 178,354,105.09 | 240,194,299.54 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 23,290.00 | - |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 25,725,893.61 | 18,519,467.61 |
| 33500 | Бусад авлага | 152,604,921.48 | 221,674,831.93 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 120,645,535.21 | 219,847,522.19 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 31,959,386.27 | 1,827,309.74 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 149,001,200.00 | 149,001,200.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 149,001,200.00 | 149,001,200.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 78,512,315.89 | 102,531,728.16 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 20,936,363.78 | 12,513,272.46 |
| 35400 | Хангамжийн материал | 57,575,952.11 | 90,018,455.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,239,868.23 | 904,796.08 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,102,575.10 | 88,880,150.84 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 233,508.78 | 233,508.78 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 9,695,567,590.83 | 9,418,448,784.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 9,695,567,590.83 | 9,418,448,784.51 |
| 39200 | Биет хөрөнгө | 9,655,312,590.83 | 9,378,268,784.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,412,869,961.10 | 9,432,326,761.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (636,809,073.01) | (852,559,467.24) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,214,470,519.81 | 1,215,788,701.61 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (337,197,055.40) | (419,662,725.96) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,068,900.00 | 3,918,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,090,661.67) | (1,543,385.00) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 40,255,000.00 | 40,180,000.00 |
| 39301 | Програм хангамж | 960,000.00 | 960,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (705,000.00) | (780,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,000,000.00 | 40,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 10,103,614,996.56 | 9,947,396,814.60 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 285,244,790.50 | 79,056,506.44 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 284,873,076.96 | 79,056,506.44 |
| 41300 | Өглөг | 284,873,076.96 | 79,056,506.44 |
| 41360 | Бусад өглөг | 284,873,076.96 | 79,056,506.44 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 268,399,392.00 | 64,142,076.89 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 107,250.00 | - |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 16,366,434.96 | 14,914,429.55 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 371,713.54 | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 42200 | Урт хугацаат зээл | 371,713.54 | - |
| 42210 | Төгрөг | 371,713.54 | - |
| 42242 | Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/ | 371,713.54 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 9,818,370,206.06 | 9,868,340,308.16 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 9,818,370,206.06 | 9,868,340,308.16 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 10,589,312,799.10 | 10,589,312,799.10 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (770,942,593.04) | (720,972,490.94) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (759,473,096.00) | (770,942,593.04) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (11,469,497.04) | 49,970,102.10 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 10,103,614,996.56 | 9,947,396,814.60 |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 201,117,979.72 | 330,857,791.61 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 201,117,979.72 | 330,857,791.61 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 201,117,979.72 | 330,857,791.61 |
| 120002 | Хүүгийн орлого | - | 289,624.78 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/ | 1,238,616,411.62 | 1,707,472,894.60 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | 1,077,498,431.90 | 1,376,904,727.77 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 40,000,000.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 177,387,476.76 | 280,887,689.51 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 177,387,476.76 | 280,887,689.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 177,387,476.76 | 280,887,689.51 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 177,387,476.76 | 280,887,689.51 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 161,867,678.13 | 246,089,726.54 |
| 210812 | Санхүүгийн зардал /ТӨҮГ/ | 14,639,798.63 | 28,189,729.37 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 880,000.00 | 1,056,000.00 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | - | 5,552,233.60 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 23,730,502.96 | 49,970,102.10 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 35,200,000.00 | - |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 35,200,000.00 | - |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (11,469,497.04) | 49,970,102.10 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,286,603,276.56 | 1,806,927,448.39 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,286,603,276.56 | 1,806,927,448.39 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,286,603,276.56 | 1,806,927,448.39 |
| 120009 | Бусад орлого | 78,127.66 | 856,543.20 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 1,286,525,148.90 | 1,806,070,905.19 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,241,962,445.89 | 1,749,889,735.41 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,241,962,445.89 | 1,749,889,735.41 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,241,962,445.89 | 1,749,889,735.41 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 262,390,644.00 | 339,214,373.00 |
| 210106 | Ажилдагчдад төлсөн /ТӨҮГ/ | 262,390,644.00 | 339,214,373.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 117,336,093.11 | 105,032,031.46 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 117,336,093.11 | 105,032,031.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 139,178,154.45 | 200,509,663.61 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 139,178,154.45 | 200,509,663.61 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 519,516,910.00 | 930,342,850.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 488,438,250.00 | 905,158,500.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 31,078,660.00 | 25,184,350.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 203,540,644.33 | 174,790,817.34 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 480,000.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 181,507,422.86 | 138,843,916.08 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 22,033,221.47 | 35,466,901.26 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 44,640,830.67 | 57,037,712.98 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 7,085,400.00 | 21,624,981.80 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,085,400.00 | 21,624,981.80 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,085,400.00 | 21,624,981.80 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,085,400.00 | 21,624,981.80 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (7,085,400.00) | (21,624,981.80) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (37,200,847.19) | (371,713.54) |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 37,200,847.19 | 371,713.54 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 37,200,847.19 | 371,713.54 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 354,583.48 | 35,041,017.64 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,825,201.27 | 2,179,784.75 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,179,784.75 | 37,220,802.39 |

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан** **(төгрөгөөр)**

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (759,473,096.00) | 9,829,839,703.10 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (759,473,096.00) | 9,829,839,703.10 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (11,469,497.04) | (11,469,497.04) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (770,942,593.04) | 9,818,370,206.06 |
| 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (770,942,593.04) | 9,818,370,206.06 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (770,942,593.04) | 9,818,370,206.06 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 49,970,102.10 | 49,970,102.10 |
| 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 10,589,312,799.10 | - | (720,972,490.94) | 9,868,340,308.16 |

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан**

**(төгрөгөөр)**

| Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Нийторлого | 1,704,746,388.00 | 1,707,472,894.60 | (2,726,506.60) | 100.16 |
| Төсөвт байгууллагын халаалтын орлого | 1,456,509,536.00 | 1,458,832,821.60 | (2,323,285.60) | 100.16 |
| Аж ахуй нэгж байгууллагын халаалтын орлого | 63,892,800.00 | 63,869,802.47 | 22,997.53 | 99.96 |
| Айл өрхийн халаалтын орлого | 184,344,052.00 | 183,880,645.75 | 463,406.25 | 99.75 |
| бусад орлого | | 889,624.78 | (889,624.78) | |
| Нийт зардал | 1,747,391,339.00 | 1,651,950,558.91 | 95,440,780.09 | 94.54 |
| Үйл ажиллагааны зардал | 1,447,030,296.00 | 1,286,476,996.15 | 160,553,299.85 | 88.90 |
| Бусад зардал | 19,859,737.00 | 11,952,464.64 | 7,907,272.36 | 60.18 |
| Тэтгэмж,шагнал урамшуулал | 3,871,715.00 | 1,056,000.00 | 2,815,715.00 | 27.27 |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 216,704,591.00 | 298,743,788.12 | (82,039,197.12) | 137.86 |
| Хөрөнгө оруулалтын зардал | 59,925,000.00 | 53,721,310.00 | 6,203,690.00 | 89.65 |
| Удирдлагын зардал /борлуулалт марктенгийн зардал | | | - | |
| Татварын төлөхийн өмнөх ашиг | (42,644,951.00) | 55,522,335.69 | (98,167,286.69) | (130.20) |
| Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын зардал | | 5,552,233.56 | (5,552,233.56) | |
| Татварын дараах ашиг | (42,644,951.00) | 49,970,102.13 | (92,615,053.13) | (117.18) |
| Нийт ажиллагсдын тоо | 32.00 | 28.00 | 4.00 | 87.50 |
| Нийт цалингийн сан | 451,066,320.00 | 415,277,402.00 | 35,788,918.00 | 92.07 |
| мөнгөний үлдэгдэл | 32,000.00 | 37,220,802.39 | (37,188,802.39) | 116,315.01 |
| нийт авлага | 127,000,000.00 | 240,191,299.54 | (113,191,299.54) | 189.13 |
| нийт өглөг | 136,000,000.00 | 79,056,506.44 | 56,943,493.56 | 58.13 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

**3.1 Залруулсан алдаа**

Аудитаар 6,574,760.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

- Мөнгөн гүйлгээний тайланд 1,187.8 мянган төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд 6,573,572.2 мянган төгрөгийн хөрөнгийн зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 589,154.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.
Аудитаар нийт 589,154.0 мянган төгрөгийн 9 зөрчил[2] илэрсэнд 8 зөрчил арилгах албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

1. Албан хаагчдад арван гурав дахь сарын цалин 30,544.7 мянган төгрөгийг урамшууллын санг байгуулаагүй, албан хаагчдын ажлыг дүгнэсэн материалгүй олгосон нь Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.6-т "Байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэлх сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Тухайн ажилтан албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно.",Байгууллагын захирлын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 33 тоот тушаалын дотоод журмын 19.4-т ""Байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэлх сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Тухайн ажилтан албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хамтын хэлэлцээрийн дагуу санг байгуулан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж урамшууллыг олгон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Цахим дэлгүүрээс 1,450.0 мянган төгрөгийн компьютер худалдан авалт хийгээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авч байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд 4 байгууллагатай холбоотой 66,124.7 мянган төгрөгийн авлагыг хоорондын тооцоог нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд 79,056.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, 14,914.4 мянган төгрөгийг өглөгийн харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийг тооцоо нийлэн барагдуулах арга хэмжээ авч зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс 20,685.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгараагүй этгээдээс худалдан авалт хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Зуухны сэлбэг хэрэгсэл, засварын ажлыг 52,550.5 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

7. Үйлчилгээний хөлс 1,720.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээ хийж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

8. Нягтлан бодогч нь авлага, өглөгийг тооцоо нийлээгүй, тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс нүүрс худалдан авсан зөрчлийг давтан гарган албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг

хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Б.Хаш-Эрдэнэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

9. Тэнүүн Алтайн шарга ХХК-аас 335,475.0 мянган төгрөгийн нүүрсийг хэмжиж, хүлээн авсан баримтгүй худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нүүрсийг хэмжиж, хяналттай хүлээн авах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ | Мөнгөн гүйлгээний тайланд 1,187.8 мянган төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 1,187.8 | - | - | 1 | 1,187.8 | 1 | 1,187.8 | - | - | - | - |
| | Санхүүгийн байдлын тайланд 6,573,572.2 мянган төгрөгийн хөрөнгийн зөрүүтэй тайлагнасан. | 1 | 6,573,572.2 | - | - | 1 | 6,573,572.2 | 1 | 6,573,572.2 | - | - | - | - |
| **Дүн** | | 2 | **6,574,760.0** | - | - | - | **6,574,760.0** | 2 | **6,574,760.0** | - | - | - | - |

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймгийн Солонго дулааны станц ААТҮГ | Албан хаагчдад арван гурав дахь сарын цалин 30,544.7 мянган төгрөгийг урамшууллын санг байгуулаагүй, албан хаагчдын ажлыг дүгнэсэн материалгүй олгосон байна. | 1 | 30,544.7 | - | - | 1 | 30,544.7 | - | - | - | - |
| | Цахим дэлгүүрээс 1,450.0 мянган төгрөгийн компьютер худалдан авалт хийгээгүй. | 1 | 1,450.0 | - | - | 1 | 1,450.0 | - | - | - | - |
| | Тайлант онд 4 байгууллагатай холбоотой 66,124.7 мянган төгрөгийн авлагыг хоорондын тооцоог нийлж баталгаажуулаагүй | 1 | 67,672.4 | - | - | 1 | 67,672.4 | - | - | - | - |
| | Тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс 20,685.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан. | 1 | 20,685.0 | - | - | 1 | 20,685.0 | - | - | - | - |
| | Тайлант онд 79,056.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, 14,914.4 мянган төгрөгийг өглөгийн харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй | 1 | 79,056.5 | - | - | 1 | 79,056.5 | - | - | - | - |
| | Үйлчилгээний хөлс 1,720.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон. | 1 | 1,720.0 | - | - | 1 | 1,720.0 | - | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Зуухны сэлбэг хэрэгсэл, засварын ажлыг 52,550.5 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зарлаагүй. | 1 | 52,550.5 | - | - | 1 | 52,550.5 | - | - | - | - |
| | Нягтлан бодогч нь авлага, өглөгийг тооцоо нийлээгүй, тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс нүүрс худалдан авсан зөрчлийг давтан гарган албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | Тэнүүн Алтайн шарга ХХК-аас 335,475.0 мянган төгрөгийн нүүрсийг хэмжиж, хүлээн авсан баримтгүй худалдан авсан байна. | 1 | 335,475.0 | | | 1 | 335,475.0 | | | | |
| **Дүн** | | **9** | **589,154.0** | - | - | **9** | **589,154.0** | | - | - | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |